



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар

8/29

Номгон

“Баянхонгорт үйлдвэрлэв - цагаан сар 2025”-
үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/28 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 25 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Баянхонгорт Үйлдвэрлэв Цагаан сар 2025” үзэсгэлэн худалдааг 2025 оны 02 дугаар сарын 13-16-ны хооронд зохион байгуулсугай.


2. “Баянхонгорт Үйлдвэрлэв- Цагаан сар 2025” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, үзэсгэлэн худалдааны удирдамжийг хоёрдугаар, шаардагдах хөрөнгийн тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үзэсгэлэн худалдаанд ач холбогдол өгч жижиг дунд, хөнгөн үйлдвэр эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэгчид болон хоршооны чиглэлээр зээл, төсөлд хамрагдсан иргэн, аж ахуй нэгжийг өргөнөөр оролцуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Үзэсгэлэн худалдаанд шаардагдах 9,962,000 (Есөн сая есөн зуун жаран хоёр мянга) төгрөгийг хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

5. Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Д.Уранчимэг)-т, чанартай, үр дүнтэй зохион байгуулахыг Ажлын хэсэг (Б.Наранбаяр)-т үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын зөвлөх (Д.Ууганцэцэг)-д даалгасугай.



Аймгийн Засаг даргын ²⁰²⁵ оны ⁰¹ дүгээр
сарын ²⁴ -ний өдрийн ^{1/29} дүгээр
захирамжийн ⁰¹ дүгээр хавсралт

“БАЯНХОНГОРТ ҮЙЛДВЭРЛЭВ-ЦАГААН САР 2025”
ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Б.Наранбаяр – Засаг даргын Орлогч

Гишүүд:

У.Балжинням - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Н.Шагдарсүрэн - Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

Б. Отгонбямба - Биеийн тамир спортын газрын дарга

Б.Дэлгэрдалай -Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн
захирал

Г. Энхтүвшин - Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга

Т.Саранчимэг – Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Анухатан - Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Монополын
эсрэг газрын улсын байцаагч

Б.Оюунцэцэг - Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хөнгөн, жижиг, дунд
үйлдвэр, хоршоо ахуйн үйлчилгээ хариуцсан ахлах
мэргэжилтэн

С.Сайнхүү - Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнс, нийтийн хоол,
худалдаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Ууганзаяа - Баянхонгор сумын Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга

Д.Уранчимэг - “Хонгорын эрхэт зангилаа” Бичил, жижиг дунд
үйлдвэлэл эрхлэгчдийн холбооны УЗ-н дарга

___оОо___

Аймгийн Засаг даргын ²⁰²⁵... оны ⁰¹... дүгээр
сарын ²⁹...-ний өдрийн ¹⁷... дүгээр
захирамжийн ⁰²... дугаар хавсралт

**“БАЯНХОНГОРТ ҮЙЛДВЭРЛЭВ- ЦАГААН САР 2025”
ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, худалдан борлуулах, ашиг орлогыг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр суурийг нь бататгах зорилгоор худалдааг зохион байгуулна.

Хоёр. Хамрах хүрээ

Баянхонгор аймгийн 20 сумын өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид, бичил жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид, бүлэг, нөхөрлөл, хоршоологчид хамрагдана.

Гурав. Хугацаа

2025 оны 02 дугаар сарын 13-16 ны өдрүүдэд Баянхонгор аймгийн төв Спортын ордонд зохион байгуулагдана.

Дөрөв. Үзэсгэлэн худалдааны хөтөлбөр

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
2025 оны 02 дугаар сарын 12-ний өдөр		
11:00-17:00	Бэлтгэл ажил хангах	“Хонгорын эрхэт зангилаа” ТББ-ын төлөөлөл
18:00-19:00	Оролцогчдыг бүртгэх, хуваарилах, бүтээгдэхүүнийг байршуулах	Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Хонгорын эрхэт зангилаа” ТББ-ын төлөөлөл
2025 оны 02 дугаар сарын 13-ний өдөр		
09:00-11:00	Үзэсгэлэн худалдаанд оролцогчдыг бүртгэх, байршуулах	Хүнс, хөдөө аж ахуйн газрын ахлах мэргэжилтэн Б.Оюунцэцэг, мэргэжилтэн С.Сайнхүү, ТББ-ын дарга Д.Уранчимэг, гишүүн Ж.Энхсайхан, Г. Жаргалсайхан, Стандарт хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн В.Оюунзул, С.Амаржаргал
11:00-12:20	Үзэсгэлэн худалдаанд оролцож байгаа сум, ААН-үүдийн танилцуулга	ТББ-ын дарга Д.Уранчимэг, гишүүн Ж.Энхсайхан
12:20-13:00	Үзэсгэлэн худалдааг нээж аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан үг хэлнэ	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга У.Балжинням, ТББ-ын дарга Д.Уранчимэг
13:00-13:10	Урлагын номер	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Саранчимэг

1	2	3
09:00-19:00	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдана	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, "Хонгорын эрхэт зангилаа" ТББ-ын төлөөлөл
2025 оны 02 дугаар сарын 14-15 –ний өдөр		
09:00-19:00	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдана. (Үзэсгэлэн худалдаанд оролцогчдод ХАА-н салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл хийх, боршур тараах, судалгаа авах, бараа бүтээгдэхүүнээс дээж авах, ТВ-ын сурвалжлага хийгдэж оролцогчдын бараа бүтээгдэхүүнийг сурталчилах)	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, "Хонгорын эрхэт зангилаа" ТББ-ын төлөөлөл
2025 оны 02 дугаар сарын 16		
16:00-17:00	Үзэсгэлэн худалдаанд оролцогчдоос шилдэгийг шалгаруулж шагнал гардуулах	Хүнс, хөдөө аж ахуйн газар, "Хонгорын эрхэт зангилаа" ТББ-ын төлөөлөл
18:00-19:00	Үзэсгэлэн худалдааг хаах, заал хүлээлгэн өгөх	Ажлын хэсэг

Тав. Шагнал

Үзэсгэлэн худалдаанд оролцогчидоос 5 төрлөөр шилдэг бүтээгдэхүүн шалгаруулж тус бүр 100,000 (нэг зуун мянга)-н төгрөгөөр шагнаж, урамшуулна.

Шагналын төрөл, тавигдах шаардлага:

1. Шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах (бэлгийн багцанд оруулах)
2. Шилдэг сав, баглаа, боодол (стандартад нийцсэн байх)
3. Шилдэг хариуцлагатай оролцогч (хариуцлагын гэрээг хэрэгжүүлсэн байх)
4. Шинэлэг инноваци нэвтрүүлсэн бүтээгдэхүүн
5. Шилдэг бүтээл

Тавигдах ерөнхий шаардлага:

- ✓ Шинийг эрэлхийлсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, хаяг шошго, савлагаатай байх
- ✓ 100 хувь Баянхонгор аймагт үйл ажиллагаа эрхэлдэг байх
- ✓ Экспортыг нэмэгдүүлсэн, импортыг орлосон бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Зургаа. Бусад

Оролцогчид дараах зүйлийг анхаарна уу.

- Зохион байгуулагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх
- Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах

- Хүнсний бүтээдэхүүний дээжийг холбогдох лабораторид шалгуулж шинжилгээний бичгийг авсан байх
- Бараа бүтээгдэхүүнийг үнийн хөөрөгдөлд оруулахгүй байх, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэх
- Сүү, цагаан идээ элдэв хольцгүй байх

Үзэсгэлэн худалдаатай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл авах бол дараах утсаар холбогдоно.

“Хонгорын эрхэт зангилаа” бичил, жижиг дунд үйлдвэл эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга Д.Уранчимэг - 80088565

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршоо ахуйн үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Оюунцэцэг – 99445656

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнс, нийтийн хоол, худалдаа хариуцсан ахлах мэргэжилтэн С.Сайнхүү – 99007803

.....оОо.....

Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр
сарын 24-ний өдрийн 1/29 дүгээр
захирамжийн ...03 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Наранбаяр

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүдэд:

Т.Эрдэнэбат

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Г.Энхбаяр

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Түвшинжаргал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг
үйлчилгээний албаны дарга

С.Гэрэлмаа – Ахлах

Нягтлан бодогч

Г.Энхбаясгалан

Нярав

Сумдын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

Д.Энхжаргал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

_____оОо_____